



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2021/09



<http://www.ubstat.mn>



АГУУЛГА

Хуудасны
дугаар

	ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2019-2021 ОН	2
	БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД	3
	НИЙГМИЙН ДААТГАЛ	4
	НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
	ЭРҮҮЛ МЭНД	7
	АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	8
	ГЭМТ ХЭРЭГ	10
	ДҮҮРГИЙН ТӨСӨВ	11
	ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	14
	ХӨДӨӨ АЖ АХУЙ	17
	ГАЗАР ТАРИАЛАН	18
	АЖ ҮЙЛДВЭР	19
	ТЭЭВЭР	22
	ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	23

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн IX сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019	2020	2021
Суурин хүн ам, сарын эцэст	хүн	181 763	190 352	198 914
Шинээр төрсөн хүүхэд	тоо	3 396	3 596	3 686
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	580	478	393
үүнээс: эмэгтэй	хүн	318	260	223
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	1 724	864	25 017
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	1 725	1 252	1 406
Хэрэглээний үнийн индексийн сарын өөрчлөлт	хувь	0.0	-0.3	0.4
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	2 667.2	2 854.0	2 848.5
Дүүргийн төсвийн орлого	сая төгрөг	62 628.8	86 556.8	137 935.0
Дүүргийн төсвийн зарлага	сая төгрөг	53 022.7	69 100.9	84 752.3



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2021 оны 9 дүгээр сард 393 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 52.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

2021 оны 9 дүгээр сард орон тооны цомхотголоор 11, байгууллага татан буугдсанаас 5, мэргэжил, эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй 2, өөр газраас шилжиж ирсэн 2, сургууль төгссөн 6, бусад шалтгаанаар 71 хүн ажилгүй болжээ. Тайлант сард 24 ажилд орсноос төрийн төсөвт байгууллагад 3, нөхөрлөл компанид 20, бусад газарт 1 хүн ажилд орсон.

Хүснэгт 2. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, 2021.IX сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2019.IX	2020.IX	2021.IX	2019.IX	2020.IX	2021.IX
Нийт ажилгүйчүүд	580	478	393	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	342	257	202	59.0	53.8	51.4
Тусгай дунд боловсролтой	17	19	14	2.9	4.0	3.6
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	24	8	13	4.1	1.7	3.3
Бүрэн дунд боловсролтой	185	174	154	32.0	36.4	39.2
Бүрэн бус дунд боловсролтой	10	15	6	1.7	3.1	1.5
Бага, боловсролгүй	2	5	4	0.3	1.0	1.0

Зураг 1. Ажилгүйчүүд насны бүлгээр, 2021.IX сард



2021 оны 9 дүгээр сард 97 хүн шинээр бүртгүүлсэн байгааг ажил хайж буй шалтгаанаар нь авч үзвэл 51.5 хувь нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байна.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 19 (4.8%) нь 15-24 насны, 155 (39.4%) нь 25-34 насны, 135 (34.4%) нь 35-44 насны, 84 (21.4%) нь 45-60 насны хүмүүс байна.



НИЙГМИЙН ДААТГАЛ

2021 оны эхний 9 сард Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 4737 байгууллагын нийт 131.0 мянган хүн хамрагдаж шимтгэл төлсөн ба тэдгээрийн 85.7 мянга (65.4%) нь ААНБ-ын, 12.3 мянга (9.4%) нь төсвийн байгууллагын, 8.4 мянга (6.4%) нь сайн дурын даатгуулагчид, 24.6 мянга (18.8%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	Өсөлт/ Бууралт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	4 228	4 737	509	12.0
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	4 109	4 613	504	12.3
Төсөвт байгууллагын тоо	119	124	5	4.2
Нийт даатгуулагчдын тоо	118 699	130 981	12 282	10.3
ААНБ-ын даатгуулагчийн тоо	83 644	85 675	2 031	2.4
Төсөвт байгууллагын даатгуулагчийн	11 363	12 276	913	8.0
Сайн дурын даатгуулагчийн тоо	8 184	8 410	226	2.8
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	15 508	24 620	9 112	58.8

2021 оны эхний 9 сард дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 212.9 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 38.3 тэрбум төгрөгөөр (22.0%) илүү бүрдсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.1 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан тус бүрээр, 2021 оны эхний IX сард

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2020 I-IX	2021 I-IX	2020 I-IX	2021 I-IX	2020 I-IX	2021 I-IX
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	73576.4	120374.4	77232.6	143936.5	105.0	119.6
Тэтгэмжийн сангийн орлого	7295.2	9 406.9	9902.6	21 862.8	135.7	232.4
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	6414.6	9 544.2	9225.9	7 089.1	143.8	74.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	1376.2	1 888.3	2018.7	6 673.7	146.7	353.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	21477.9	33 376.7	21477.9	33 376.7	100.0	100
Нийт	110140.3	174 590.5	119857.7	212938.8	108.8	122


Тайлбар: * ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 67.6 хувь нь тэтгэврийн даатгалын сангийн, 10.3 хувь нь тэтгэмжийн даатгалын сангийн, 3.3 хувь нь ҮОМШӨ-ний даатгалын сангийн, 3.1 хувь нь ажилгүйдлийн даатгалын сангийн, 15.7 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого тус тус эзэлж байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 3. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 17311 хүнд 75.8 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 3285 хүнд 9.8 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 836 хүнд 2.6 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1264 хүнд 8.1 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 10176 хүнд 1.8 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 4380 хүнд 9.1 тэрбум төгрөгийг, 65 хүнд оршуулгын тэтгэмж 63.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 159 хүнд 778.1 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 18 хүнд 108.6 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 47 хүнд 75.0 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувиллын зардал 3 хүнд 1.3 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1943 хүнд 4.8 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 67.1 хувийг тэтгэврийн, 10.4 хувийг тэтгэмжийн, 3.4 хувийг ҮОМШӨ-ний, 3.3 хувийг ажилгүйдлийн, 15.8 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 4. Даатгалын сангийн орлого, зарлага сая,төг



Зураг 5. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо





НИЙГМИЙН ХАЛАМЖ

2021 оны эхний 9 сард нийгмийн халамжийн сангийн нийт 56.0 хувь нь нийгмийн халамжийн сан, 3.5 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл, хүүхэдтэй, 3.4 хувь нь хүнс тэжээл хөтөлбөр, 6.3 хувь нь алдарт эхийн одонгийн тусламж, 7.3 хувь нь насны хишиг, 21.6 хувь нь цалинтай ээж, 1.8 хувь нь өрх толгойлсон эцэг эхэд тэтгэмж, 0.1 онцгой тохиолдолд олгох тэтгэмж хөтөлбөрт тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 55.6 хувь нь нийгмийн халамжийн санд буюу нийт 16 122 хүнд, 10 223 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 40 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 17 316 хүнд эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжид тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2021 оны IX сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	19 746.5	
А. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	19 738.5	
1) Нийгмийн халамжийн сан	11 045.8	
2) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	698.3	
3) хүнс тэжээл хөтөлбөр	671.3	
4) алдарт эхийн одонгийн тусламж	1 249.3	
5) насны хишиг	1 444.7	
6) цалинтай ээж хөтөлбөр	4 255.6	
7) өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмж	355.5	
8) онцгой тохиолдолд олгох тэтгэмж	18.0	
Б. Хүүгийн болон бусад орлого	8.0	
а) хүүгийн орлого	2.6	
б) бусад орлого	5.4	
Зарлагын нийт дүн	19 600.9	64 227
1. Нийгмийн халамжийн сан	10 899.2	16 122
2. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	5 312.8	17 316
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1 252.8	10 223
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5.3	40
5. Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	665.7	11 537
6. Насны хишиг	1 447.1	8 974
7. Онцгой тохиолдолд олгох тэтгэмж	18.0	15




ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 9 сард 25017 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 24153 хүнээр (29 дахин), 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 1265.1 продицмилээр нэмэгдсэн байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 99.0 хувийг ковид-19, 0.4 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 0.2 хувийг тэмбүү, 0.1 хувийг трихомониаз, 0.1 хувийг заг хүйтэн, 0.1 хувийг цусан суулга, 0.1 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо нэмэгдэхэд коронавирусын халдвараар өвчлөгчид 24758 (99.0%)-аар нэмэгдсэн нь нөлөөлжээ.


Хүснэгт 6. Дүүрэгт гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний IX сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 I-IX	2021 I-IX	Өсөлт, бууралт	
				2021/2020	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	864 47.5	25017 1312.6	24153 1265.1	29.0 дах
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	10 0.5	4 0.2	-6 -0.3	-60.0
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	200 11.0	39 2.0	-161 -9.0	-80.5
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	14 0.8	0 0	-14 -0.8	-100.0
Сальмонеллөз	Бодит тоо 10000 хүнд	13 0.7	1 0.1	-12 -0.6	-92.3
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	135 7.4	1 0.1	-134 -7.3	-99.2
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	2 0.1	0 0	-2 -0.1	-100
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	3 0.2	0 0	-3 -0.2	-100
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	39 2.1	2 0.1	-37 -2.0	-94.9
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	130 7.1	40 2.1	-90 -5.0	-69.2
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	30 1.6	28 1.5	-2 -0.1	-6.7
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	34 1.9	22 1.2	-12 -0.7	-35.3
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	189 10.4	112 5.9	-77 -4.5	-40.7
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	13 0.7	2 0.1	-11 -0.6	-84.6
Ковид 19	Бодит тоо 10000 хүнд	32 1.8	24758 1299.0	24726 1297.2	773.6
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	20 1.2	8 0.5	-12 -0.7	-60.0

Зураг 6. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 7. Халдварт өвчнөөр өвчлөгчид



2021 оны эхний 9 сард эхийн эндэгдэл 2 болж, нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 4 хүүхдээр нэмэгдэж, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2 хүүхдээр буурсан байна.

Хүснэгт 7. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний IX сард

Үзүүлэлт	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021}{2020} \%$
Амаржсан эхийн тоо	3366	3569	3649	2.2
Амьд төрсөн хүүхэд	3396	3596	3686	2.5
Төрөхийн улмаас эндсэн эх	-	-	2	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	25	22	26	18.2
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	5	5	3	-40.0

*Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв



АМЬДАРЧ БУЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2021 оны 9 дүгээр сард дунджаар 10.4°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.6°C-аар хүйтэн, олон жилийн дундажтай харьцуулбал 0.4°C-аар дулаан байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 24.8°C, хамгийн хүйтэн хэм -5.6°C, хур тунадасны нийлбэр 52.8 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 16 метр секунд хүрсэн байна.

Хүснэгт 8. Агаарын бохирдолт, мг/м³, IX сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	329	0.066	5	0.011
Азотын давхар исэл	NO ₂	0.050	268	0.067	24	0.028
Тоосжилт	PM ₁₀	0.100	335	0.193	13	0.041
	PM _{2.5}	0.050	191	0.037	-	0.012
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	877	3.429	-	0.577
Озон	O ₃	0.100	439	0.080	-	0.031

¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж

Хүснэгт 9. Хан-Уул дүүргийн агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, IX сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл – экспо төв			Нисэх		
		2019	2020	2021	2019	2020	2021
		Мг/м ³					
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.006	0.006	0.006	-	0.010	-
	Хамгийн их	0.018	0.026	0.015	-	0.019	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	24	30	30	-	30	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	-	-	-	0.014	0.020	-
	Хамгийн их	-	-	-	0.023	0.034	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	16	14	-
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO**	Дундаж	-	-	0.412	-	0.366	-
	Хамгийн их	-	-	1.048	-	1.018	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	90	-	90	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.097	-	0.027	0.133	0.016	-
	Хамгийн их	0.254	-	0.038	0.301	0.029	-
	XXX*-с давсан хувь	46.0	-	-	50.0	-	-
	Хэмжилтийн тоо	24	-	30	16	30	-
Тоос PM ₂₅	Дундаж	-	0.067	-	0.028	0.070	-
	Хамгийн их	-	0.143	-	0.055	0.162	-
	XXX*-с давсан хувь	-	7.0	-	13.0	17.0	-
	Хэмжилтийн тоо	-	29	-	16	30	-
Озон O ₃ **	Дундаж	-	0.016	-	-	0.049	-
	Хамгийн их	-	0.051	-	-	0.091	-
	XXX*-с давсан хувь	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	90	-	-	90	-

* Хүлцэх хэм хэмжээ

** CO, O₃ -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны 9-р сарын танилцуулга

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны 9 дүгээр сарын 08, 09-ний өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 2.2 дахин, амоны азот 2 дахин, эрдэс фосфор 1.5 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 9 сард 1406 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 154 (12.3%) хэргээр өссөн байна.

Зураг 8. Гэмт хэргийн тоо, жил бүрийн I-IX сард



Нийт гэмт хэргийн 314 (22.3%) нь хулгайн хэрэг, 319 (22.6%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 1(0.1%) нь малын хулгай, 1(0.1%) нь олон нийтийн аюулгүй байдлын эсрэг, 403 (28.7%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 21 (1.5%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 14 (1.0%) нь хүчингийн хэрэг, 12 (0.9%) нь дээрэмдэх хэрэг, 49 (3.5%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 8 (0.6%) нь хүнийг алах хэрэг, 264 (18.7%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.


Хүснэгт 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн I-IX сард

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021}{2020} \%$	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	6	21	3.5*	15
Хүчин	14	14	-	-
Дээрэмдэх	11	12	9.1	1
Хулгай	361	314	-13.0	-47
Залилан мэхлэх	245	403	64.5	158
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	295	319	8.1	24
Малын хулгай	10	1	-90.0	-9
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	-	1	-	1
Хүнийг санаатай алах	9	8	-11.1	-1
ХАБТХАЖЭ	47	49	4.2	2
Бусад	254	264	3.9	10
Бүгд	1252	1406	154	12.3

*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт 314 хулгайн гэмт хэргийн 295 (94.0%) нь иргэний өмчийн хулгай, 5 (1.6%) нь авто тээврийн хэрэгслийн хулгай, 14 (4.4%) нь халаасны хулгайн хэрэг эзэлж байна.

Зураг 9. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



Хүснэгт 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэл	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	ХАБТХАЖЭ	Бусад
	2020 I-IX	2021 I-IX	Тоо	Хувь							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл	Халаасны хулгай						
1	59	56	-3	-5.1	-	1	9	-	1	13	10	1	2	1	14	-	-	2	15
2	81	88	7	8.6	1	1	26	-	1	14	13	-	1	2	27	-	-	3	13
3	133	130	-3	-2.2	-	-	23	-	-	21	19	-	2	2	46	-	-	8	30
4	132	139	7	0.7	1	1	42	-	-	34	32	-	2	1	39	-	-	5	16
5	23	20	-3	-13.0	1	-	8	-	-	5	5	-	-	1	2	-	-	-	3
6	25	25	-	-	1	1	6	-	-	6	6	-	-	-	4	-	-	3	4
7	15	16	1	6.7	-	1	4	-	1	1	1	-	-	-	3	-	-	2	4
8	37	47	10	27.0	-	3	16	1	2	3	3	-	-	1	8	-	-	1	13
9	37	26	-11	-29.7	-	1	16	-	-	2	2	-	-	-	3	-	-	-	4
10	70	43	-27	-38.6	1	1	11	-	-	10	10	-	-	-	8	-	-	5	7
11	163	165	2	1.2	-	2	31	-	2	42	40	1	1	1	43	-	-	7	37
12	38	33	-5	-13.1	1	2	13	-	2	8	7	1	-	-	3	-	-	-	4
13	19	25	6	3.6	1	3	12	-	-	2	2	-	-	-	3	1	-	1	2
14	43	24	-19	-44.2	-	-	6	-	-	5	4	1	-	-	6	-	-	1	6
15	167	170	3	1.8	-	1	21	-	-	46	44	-	2	-	58	-	-	7	37
16	53	65	12	22.6	-	1	17	1	-	12	12	-	-	-	21	-	-	2	12
17	32	79	47	146.9	-	-	11	1	2	27	26	1	-	1	23	-	1	-	14
18	17	39	22	129.4	-	-	5	-	-	18	17	-	1	-	6	-	-	-	10
19	27	73	46	170.4	-	-	7	-	-	12	11	-	1	-	42	-	-	1	11
20	30	88	58	193.3	-	2	23	-	3	17	16	-	1	1	28	-	-	-	14
21	51	55	4	7.8	1	-	12	-	-	16	15	-	1	1	16	-	-	1	8
Дүн	1252	1406	154	12.3	8	21	319	3	14	314	295	5	14	12	403	1	1	49	264


*ХАБТХАЖЭ-Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого (урсгал орлого болон тусламжийн орлого) 2021 оны эхний 9 сард 137.9 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 20.0 тэрбум төгрөгөөр (12.7%) дутуу бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2020 оноос 59.4 хувь өссөн байна. Төсвийн нийт орлогын 33.4 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 1.8 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 36.0 хувийг тусламжийн орлого, 28.8 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Зураг 10. Төсвийн орлого, зарлага, 2013-2021 онд, сая төг



Татварын орлогын хэмжээ 46.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 10.9 тэрбум төгрөгөөр (19.1%) дутуу бүрдсэн бол, татварын бус орлого 91.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 9.2 тэрбум төгрөгөөр (9.1%) тус тус дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 12. Дүүргийн төсвийн орлого, 2021 оны эхний IX сард, сая.төг

Төсвийн орлого				Үүнээс:					
Бүгд	ТБ %	Зөрүү сая.төг	Татварын орлого			Татварын бус орлого			
			Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
Дүн	137935.0	87.3	-20050.1	46108.8	80.9	-10888.6	91826.2	90.9	-9161.6

Хүснэгт 13. Дүүргийн татварын бус орлого, 2021 оны эхний IX сард, сая.төг

Татварын бус орлого	Үүнээс:									
	Нийтлэг татварын бус орлого			Тусламжийн орлого			Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгийн орлого			
Дүн	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	Бүгд	ТБ %	Зөрүү сая.т	
	91826.2	2439.4	100.2	5.6	49653.2	84.4	-9169.8	39733.7	100.0	2.7


Орлогын албан татвар төлөвлөснөөс 971.1 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 32.8 сая төгрөгөөр, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 9.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 14. Дүүргийн төсвийн орлого, 2021 оны эхний IX сард, сая.төг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ хувь	Зөрүү
Орон нутгийн орлого	157985.2	137935.0	87.3	-20050.1
1.Татварын орлогын дүн	56997.5	46108.8	80.9	-10888.6
1.1 Орлогын албан татвар	37131.5	36160.3	97.4	-971.1
Хувь хүний орлогын албан татвар	37131.5	36160.3	97.4	-971.1
1.2 Хөрөнгийн албан татвар	75.2	42.4	56.4	-32.8
1.3 Бусад татвар,төлбөр, хураамж	19790.8	9906.1	50.1	-9884.6
1.3.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	5960.8	2793.2	46.9	-3167.5
Улсын тэмдэгтийн хураамж	4442.1	2115.2	47.6	-2326.9
Ашигт малтмал ашигласны төлбөр	58.7	93.4	159.2	34.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1460.0	584.6	40.0	-875.4
1.3.2 Газрын төлбөр	13825.0	7095.7	51.3	-6729.3
1.3.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	5.0	17.2	343.2	12.2
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	5.0	17.2	343.2	12.2
2.Татварын бус орлогын дүн	100987.7	91826.2	90.9	-9161.6
2.1 Нийтлэг бус татварын орлого	2433.8	2439.4	100.2	5.6
Хүүгийн орлого	0	0	0	0
Торгуулийн орлого	1950.0	1818.7	93.3	-131.3
Төсөвт байгууллагын өөрийн орлого*	468.7	594.5	126.8	125.8
Бусад орлого	15.1	26.2	174.0	11.1
2.2 Тусламжийн орлого	58823.0	49653.2	84.4	-9169.8
Хандив тусламж /дотоод/	30.7	0	0	-30.7
Төслөөс санхүүжих	58792.3	49653.2	84.5	-9139.1
2.3 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	39730.9	39733.6	100.0	2.7
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	39226.1	39226.1	100.0	0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	504.8	507.5	100.5	2.7

*Төсөвт байгууллагын өөрийн орлого нь үндсэн болон туслах орлогын нийлбэр дүн

Зураг 11. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 12. Татварын бус орлогын бүтэц, хувиар



2021 оны эхний 9 сард орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 84.7 тэрбум төгрөгийн (76.4%) зардлыг санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 26.1 тэрбум төгрөгийг (23.6%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Төсвийн нийт зарлагын 30.6 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 3.8 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 37.1 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 28.5 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 15. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2021 оны эхний IX сард, сая.төг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийт дүн	137935	110912.1	84752.3	76.4	-26159.7	53182.7

Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 1544.8 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 564.6 сая төгрөгийн өглөг шинээр үүсч, сарын эцэст нийт 2.0 тэрбум төгрөгийн өглөгтэй болсон байна.

Хүснэгт 16. Өглөг, 2021 оны эхний IX сард, сая.төг


	09-р сарын эхний үлдэгдэл	Шинээр үүссэн өглөг	Тухайн сард төлөгдсөн	09-р сарын эцсийн үлдэгдэл
Нийт дүн	1544.8	564.6	121.4	1988.0



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2021 оны 9 дүгээр сарын хэрэглээний үнийн индекс 2020 оны эцэстэй харьцуулахад 10.4 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.4 хувиар тус тус өссөн байна.

Зураг 13. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 10.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 12.3 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 3.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 27.9 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 2.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 6.6 хувь, тээвэр бүлгийн үнэ 16.8 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 2.0 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 1.4 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 5.6 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 14.3 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 6.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. 2021 оны 9 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 26.5 хувийнх нь үнэ өсөж, 6.4 хувийнх нь үнэ буурч, 67.2 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

Хүснэгт 17 . Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2020-IX 2019-IX	2021-IX 2020-IX	2021-IX 2020-XII	2021-IX 2021-VIII
Ерөнхий индекс	101.4	109.9	110.4	100.4
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	100.9	115.0	112.3	99.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.5	104.0	103.8	100.2
Хувцас, бөс бараа, гутал	103.7	101.4	99.3	100.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.7	108.5	127.9	101.7
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.7	102.9	102.0	100.3
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.8	107.8	106.6	100.5
Тээвэр	94.4	118.9	116.8	101.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.1	102.0	102.0	101.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.7	101.5	101.4	100.2
Боловсролын үйлчилгээ	100.6	105.6	105.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	104.6	115.6	114.3	100.0
Бусад бараа, үйлчилгээ	106.6	106.8	106.1	101.5

Хүснэгт 18. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /**зөрөг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	0.6	Энэ бүлгийн үнийн бууралтад мах, махан бүтээгдэхүүний үнэ 2.7 хувиар, хүнсний ногооны үнэ 10.3 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлөв.
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд архи, спиртны үнэ 0.4 хувиар, шар айрагны үнэ 0.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
Хувцас, бөс бараа, гутал	0.3	Хувцас, бөс бараа, гуталын бүлгийн үнийн өсөлтөд жижиг эдлэл, хэрэгслийн үнэ 1.9 хувиар, бүх төрлийн хувцасны үнэ 0.3 хувиар өссөн нь тус тус нөлөөлөв.
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	1.7	Энэ бүлгийн үнийн өсөлтөд орон сууцны урсгал засварын бараа, материалын үнэ 4.3 хувиар, хатуу түлшний үнэ 3.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.3	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнийн өсөлтөд хивс болон шалны бусад дэвсгэрийн үнэ 1.3 хувиар, жижиг багаж хэрэгслийн үнэ 1.1 хувиар хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлөв.
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд эм, тарианы үнэ 0.6 хувиар, шүдний эмнэлгийн үйлчилгээний үнэ 3.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлөв.
Тээвэр	1.2	Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд авто замын зорчигч тээврийн үйлчилгээний үнэ 8.3 хувиар өссөн нь шууд нөлөөлжээ.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.6	Энэ бүлгийн үнийн өсөлтөд телефон утас, факсын үйлчилгээний үнэ 1.7 хувиар өссөн нь шууд нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.2	Энэ бүлгийн үнийн өсөлтөд фото зураг, кино зургийн хэрэгсэл, дурангийн үнэ 6.8 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	1.5	Энэ бүлгийн үнийн өсөлтөд үсчин болон гоо сайхны үйлчилгээний үнэ 1.2 хувиар, гоо сайхны хэрэгцээнд зориулсан бусад эд зүйлсийн үнэ 1.3 хувиар, бусад үйлчилгээний үнэ 8.0 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.


2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Фүжи алим 2700 төгрөг, “Хонины мах”, ястай 1800 төгрөг, “Үхрийн мах” ястай 3000 төгрөг, Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 100 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 40 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурил 50 төгрөг, Байцаа 350 төгрөг, Лууван 2000 төгрөг, Сонгино 1000 төгрөг, Задгай сүү 700 төгрөг, Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК 600 төгрөгөөр тус тус өссөн. Төмс 200 төгрөг, Манжин 350 төгрөг, Цагаан будаа 225 төгрөг, Элсэн чихэр 1026 төгрөгөөр тус тус буурсан. Харин “Талх чихэр” ХК-ны “Атар” талхны үнэ тогтмол буюу 1300 төгрөг байлаа.

Хүснэгт 19. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, төгрөг, жил бүрийн IX сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2020.IX	2021.IX	$\frac{2021}{2020} \%$
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	Ширхэг	1 300	1300	100.0
Хонины мах, ястай	Кг	7 500	9300	124.0
Үхрийн мах, ястай	Кг	10 000	13000	130.0
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа”	Кг	1 550	1650	106.5
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа”	Кг	1 360	1400	102.9
Гурил ,2-р зэрэг, “Алтан тариа”	Кг	1 000	1050	105.0
Элсэн чихэр	Кг	2 700	1674	62.0
Төмс, монгол	Кг	1 000	800	80.0
Байцаа, монгол	Кг	1 000	1350	135.0
Лууван, монгол	Кг	1 000	3000	300.0
Манжин, монгол	Кг	2 600	2250	86.5
Сонгино, хятад	Кг	1 500	2500	166.7
Цагаан будаа	Кг	3 000	2775	92.5
Алим, фүжи	Кг	4 900	7600	155.1
Сүү, задгай	литр	1 500	2200	146.7
Тараг, цөцгийтэй, “Сүү ” ХК	литр	2 640	3240	122.7

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүвара” төв


Зураг 14. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг



Зураг 15. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 16. Нэг кг төмс, лууван, байцааны



Зураг 17. Нэг кг манжин, сонгины



Хүснэгт 20. Нэг литр шатахууны үнэ, төгрөг

ШТС	2020.IX.30					2021.IX.29				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	-	1300	1370	1850	-	-	1940	1980	2340	-
Петровис	2000	1400	1450	2090	-	2650	2000	2050	2490	-
Магнай трейд	2000	-	1420	2090	-	2650	-	2050	2490	-
Сод монгол	2000	-	1450	2090	-	2650	-	2050	2490	-
Шунхлай	2000	-	1450	2090	-	2550	-	2050	2490	-
Юнигаз	-	-	-	-	1130	-	-	-	-	1640
Дундаж үнэ	2000	1350	1428	2042	1130	2625	1970	2036	2460	1640

*Мэдээллийн эх сурвалж: Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний үнийн 9-р сарын мэдээ



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 9 сард 10022 хээлтэгч мал төллөжээ. Нийт гарсан төлөөс 691 (6.9%) нь хорогдож, 9347 (93.1%) төл бойжиж байна.

Хүснэгт 21. Төл бойжилт, төрлөөр, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Төллөсөн хээлтэгч мал	10 246	10 022	-	960	3 166	3 623	2 273
Гарсан төл	10 283	10 038	-	960	3 166	3 633	2 279
Үүнээс: Хорогдсон төл	440	691	-	59	43	387	202
Бойжсон төл	9 843	9 347	-	901	3 123	3 246	2 077


Бойжсон нийт төлийн 9.6 хувийг унага, 33.4 хувийг тугал, 34.7 хувийг хурга, 22.3 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 22. Том малын зүй бус хорогдол, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2020 I-IX	2021 I-IX	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	847	2 077	-	240	218	790	829
Үүнээс: өвчнөөр хорогдсон	25	-	-	-	-	-	-
Хорогдсон хээлтэгч	374	728	-	44	79	286	319

Дүүргийн хэмжээнд 2021 оны эхний 9 сард 2077 толгой мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1230 толгой малаар өсжээ. Нийт хорогдлын 22.0 хувийг бод мал, 78.0 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 35.1 хувь буюу 728 хээлтэгч мал хорогдсон байна.

Зураг 18. Том малын зүй бус хорогдол, эхний 9 сард




ГАЗАР ТАРИАЛАН

2021 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд 4.0 тонн төмс, 581.7 тонн хүнсний ногоо хураан авсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хүнсний ногоо 12.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 23. Хураасан ургац, нэр төрлөөр, IX сард

	2020-IX	2021-IX	Өсөлт бууралт /хувиар/
Төмс	117.5	4.0	-96.6
Хүнсний ногоо	519.4	581.7	12.0
Байцаа	309.5	55.2	-82.2
Лууван	10.1	11.2	10.9
Шар манжин	6.7	8.8	31.3
Улаан манжин	3.9	6.4	64.1
Сонгино	10.2	10.7	4.9
Сармис	1.9	1.3	-31.6
Өргөст хэмх	155.4	450.1	2.9 дах
Улаан лооль	6.4	19.5	3.0 дах
Тарвас	0.13	-	-
Амтат гуа	0.022	-	-
Хулуу	2.4	15.2	6 дах
Чинжүү	2.1	1.1	-47.6
Бусад	10.7	2.2	-79.4

Зураг 19. Хураасан ургац, IX сард






АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн байгууллагууд 2021 оны эхний 9 сард 736.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 998.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 99.8 хувиар буурч, борлуулалт 116.6 хувиар өссөн байна.

Зураг 20. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2020-2021 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 703.2 тэрбум төгрөгийг дотоодод, 295.0 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 29.5 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 12.0 хувийг хувцас үйлдвэрлэл, 1.2 хувийг ээрэх нэхэх даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл, 0.4 хувийг ундаа үйлдвэрлэлт, 86.4 хувийг ашигт малтмалын олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 21. Үйлдвэрлэлт, 2019-2021 он, тэрбум төг



Зураг 22. Борлуулалт, 2019-2021 он, тэрбум төг



Хүснэгт 24. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Нийт бүтээгдэхүүн		
	2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021}{2020} \%$
Уул уурхай олборлох үйлдвэр	1 362.6	37 098.0	27.2*
Металлын хүдэр олборлолт	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	1 362.6	37 098.0	27.2*
Боловсруулах үйлдвэр	645 979.3	606 197.5	93.8
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	298 346.3	370 161.4	124.1
Мах боловсруулах, консервлох	3 276.6	1 836.2	56.0
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	3 538.4	1 732.1	48.9
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	38 991.3	84 669.4	2.2*
Үр тарианы гурлын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	-	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	36 014.9	27 514.6	76.4
Малын тэжээл үйлдвэрлэл	-	8 997.8	-
Ундаа үйлдвэрлэл	216 525.1	245 411.3	113.3
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	207 128.4	25 973.3	12.5
Хувцас үйлдвэрлэл	35 790.1	93 495.6	2.6*
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 946.0	5 994.2	67.0
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 746.9	27 102.7	3.1*
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх н үйл ажиллагаа	15 644.6	10 748.7	68.7
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	29 477.1	32 018.1	108.6
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	11 895.4	11 869.7	99.7
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 251.8	3 152.8	140.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	10 806.9	13 024.8	120.5
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	118.6	1 719.5	14.5
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 111.0	179.0	16.1
Тавилга үйлдвэрлэл	4 155.6	4 276.3	102.9
Бусад боловсруулах үйлдвэрлэл	7 190.3	822.4	11.4
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	4 370.3	5 659.0	129.5
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	85 788.6	81 654.7	87.5
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	4 517.0	11 565.9	2.6*
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	257.6	6 907.8	26.8
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	4 259.4	4 658.1	109.4
ДҮН	737 647.5	736 516.1	99.8

Тайлбар: *дахин

Хүснэгт 25. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, оны үнээр, сая төгрөг

Салбар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2020 I-IX	2021 I-IX	$\frac{2021}{2020} \%$	үүнээс: экспорт, %
Уул уурхай олборлох үйлдвэр	1 339.8	37 098.0	27.6*	86.4
Металлын хүдэр олборлолт	-	-	-	-
Бусад ашигт малтмал олборлолт	1 339.8	37 098.0	27.6*	86.4
Боловсруулах үйлдвэр	764 554.2	867 707.7	113.5	13.6
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	541 144.0	638 551.4	118.0	-
Мах боловсруулах, консервлох	9 897.8	6 165.1	62.3	-
Жимс болон төмс, хүнсний ногоо боловсруулалт, хадгалалт	7 000.9	1 643.1	23.5	-
Сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	61 095.3	113 914.3	186.4	-
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	35 519.2	27 538.4	77.5	-
Үр тарианы гурлын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүн үйлдвэрлэл	-	-	-	-
Малын тэжээл үйлдвэрлэл	-	8 997.8	-	-
Ундаа үйлдвэрлэл	427 630.8	480 292.7	112.3	0.4
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	99 329.5	34 023.0	34.2	1.2
Хувцас үйлдвэрлэл	16 779.0	72 325.7	4.3*	12.0
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 440.8	6 107.5	72.3	-
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8 546.9	27 382.8	3.2*	-
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	13 657.5	10 755.0	78.7	-
Химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	29 447.5	32 093.1	109.0	-
Үндсэн эмийн бүтээгдэхүүн болон эмийн бэлдмэлийн үйлдвэрлэл	14 225.2	16 513.7	116.1	-
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 428.8	3 152.8	129.8	-
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	11 496.9	13 876.1	120.7	-
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	118.6	1 591.9	13.4	-
Компьютер, электроник болон оптик бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1 111.0	178.2	16.0	-
Тавилга үйлдвэрлэл	4 155.6	4 350.2	104.7	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	7 964.9	1 049.3	13.2	-
Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ	5 708.0	5 757.0	100.8	-
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	85 788.6	81 654.7	87.5	-
Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3 980.1	11 718.0	2.9	-
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	258.1	6 907.8	26.8	-
Хүрээлэн буй орчны бохирдлыг ариутгах, цэвэрлэх, бусад хог хаягдлын менежментийн үйлчилгээ	3 722.0	4 810.2	129.2	-
ДҮН	855 662.7	998 178.4	116.6	-



ТЭЭВЭР

Тээвэр, тээвэр зуучлал, агуулахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд 2021 оны 3 дугаар улиралд 10991.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2587.6 сая төгрөгөөр (30.8%) өссөн байна.

Хүснэгт 26. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, III улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 I-IX	2021 I-IX
Нийт орлого	сая.төгрөг	8404.2	10991.8
Тээвэрлэсэн ачаа	мян.тн	287.5	15.8
Ачаа эргэлт	мян.т.км	8548.3	5884.5

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2021 оны эхний 9 дүгээр сарын байдлаар Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 1750 өргөдөл, гомдол ирснээс хуулийн дагуу хугацаанд нь 1659 өргөдөл, гомдолд хариу өгч, хугацаа хэтэрсэн 25, шийдвэрлэх хугацаа болоогүй 66 өргөдөл байна.

Хүснэгт 27. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга					Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим	Гомдол	Санал	Талархал	Мэдэгдэл	Хүсэлт					
Удирдлага	5	-	4	-	1	1	-	-	-	4	5	-	-	5	-
ТЗУХ	84	-	60	24	-	22	-	5	-	57	75	1	8	84	-
СТСХ	3	-	3	-	-	-	-	-	-	3	3	-	-	3	-
ТГХХ	44	-	7	11	26	10	4	-	-	30	43	1	-	44	-
НХХ	26	-	20	5	1	3	1	1	-	21	25	1	-	26	-
ТНААХ	229	-	26	145	58	138	20	1	4	66	203	19	7	229	-
ХХҮХ	198	-	177	16	5	10	2	-	-	186	195	2	1	198	-
ХЗТ	15	-	9	5	1	8	-	-	-	7	15	-	-	15	-
Цэргийн штаб	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ЗДТГ-ын дүн	604	0	306	206	92	192	27	7	4	374	564	24	16	604	0
ХөХҮХ	17	-	8	9	-	7	2	-	-	8	17	-	-	17	-
Газрын алба	516	-	461	40	15	25	5	-	-	486	482	27	7	516	-
Боловсролын хэлтэс	15	-	3	11	1	12	-	-	-	3	15	-	-	15	-
ОБХ	3	-	-	3	-	2	-	-	-	1	3	-	-	3	-
Албан бус-НТБ төв	19	-	19	-	-	-	-	-	-	19	19	-	-	19	-
Бүртгэлийн хэлтэс	36	-	4	31	1	23	3	-	-	10	35	1	-	36	-
ГБХЗХХ	69	-	67	2	-	1	-	1	-	67	58	10	1	69	-
МХХ	345	-	142	194	9	264	2	-	-	79	343	1	1	345	-
Татварын хэлтэс	60	-	56	4	-	3	1	-	-	56	60	-	-	60	-
НДХ	44	-	44	-	-	3	-	-	-	41	43	1	-	44	-
Цагдаагийн газар	22	-	8	10	4	11	2	3	-	6	20	2	-	22	-
Дэргэдэх хэлтэс, албадын дүн	1146	0	812	304	30	351	15	4	0	776	1095	42	9	1146	0
Нийт дүн	1750	0	1118	510	122	543	42	11	4	1150	1659	66	25	1750	0

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Танилцуулгыг эрхлэн гаргасан: Мэргэжилтэн Ч.Хишигжаргал



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

2021 оны эхний 9 сар



Амаржсан эх

Төрсөн хүүхэд



2020.I-IX 3 569

2021.I-IX 3 649



2020.I-IX 3 596

2021.I-IX 3 686



Халдварт өвчнөөр
өвчлөгчид



Бүртгэгдсэн гэмт хэрэг



2020.I-IX 864

2021.I-IX 25 017



2020.I-IX 1 252

2021.I-IX 1 406



Бүртгэлтэй ажилгүй иргэд

2020.IX

2021.IX

478

393

♀

260

♀

223





Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, борлуулалт

Үйлдвэрлэлт, тэрбум.төг

2020.I-IX **737.6**

2021.I-IX **736.5**

Борлуулалт, тэрбум.төг

2020.I-IX **855.7**

2021.I-IX **998.2**



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн
индексийн жилийн өөрчлөлт, хувь

2020.IX **-0.3**

2021.IX **0.4**



Валютын зах
зээлийн ханш

\$

1US\$ = ₮

2020.IX **2 854.0**

2021.IX **2 848.5**



Дүүргийн төсөв, сая.төг

Орлого

2020.I-IX **85 556.8**

2021.I-IX **137 935.0**



Зарлага

2020.I-IX **69 100.9**

2021.I-IX **84 752.3**

Дэлгэрэнгүйг <http://www.ubstat.mn/Report> хуудаснаас авна уу

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn